

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2025 оны хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр (2021 - 2026), “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” (2017 - 2026), ЭМДҮЗ-ийн 04-р тогтоол, Төвийн дүрмийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төрөлжсөн мэргэшлийн тасаг нэгжийн эрхлэгч нарын ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллах тасаг, албадын эрхлэгч нарын ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. ЭХЭМҮТ-ийн хөгжлийн хөтөлбөр, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэн, ажлын гүйцэтгэлийн шалгуурыг ханган ажиллахыг тасаг нэгжийн эрхлэгч, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр дүгнэж, хяналт тавьж, захиралд тайлагнан ажиллахыг Эмнэлзүй хариуцсан тэргүүн дэд захирал /Л.Ганбаяр/, Хүүхдийн эмнэлэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийг хариуцсан дарга /Т.Болормаа, Х.Цолмон/, Төлөвлөлт, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/, Эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа хариуцсан дэд захирал /Д.Энхмаа/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтан /Н.Анандра/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.Отгонбаатар

Ж.ОТГОНБААТАР

20250047

Захирлын оны сарын өдрийн
 А/39.. тоот тушаалын ... хавсралт

**ЭХЭМҮТ-ийн төрөлжсөн мэргэшлийн тасаг нэгжийн эрхлэгч нарын
 ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

№	Үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо
I. Эдийн засгийн хувьд үр өгөөжтэй ажилласан байдал			
1	Хариуцсан тасгийн ЭМД-ын цахим түүхийн бичилтийн хувийг 95%-иас доошгүй ажиллана (хасагдалыг бууруулсан)	10	
2	Зардал бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр тайлагнасан (илүү цагийн хөлс, шинжилгээний тоо хэмжээ, эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, ус дулаан, цахилгааны хэрэглээ)	5	
II. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил			
1	Импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хэвлүүлсэн	5	
2	Олон улсын хурал, семинарт илтгэл хэлэлцүүлсэн	5	
3	Тасаг нэгжийг манлайлан, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн	5	
4	Тасгийн эмч нараас аймаг, дүүргийн эмнэлэгт 1-2 сэдвээр илтгэл тавьсан, мэргэжлийн чиглэлээр лекц сургалт зохион байгуулсан	5	
III. Мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил			
1	Шинэ санаа оновчтой бүтээлийн гэрчилгээ авсан (патент)	5	
2	Мэргэжлийн ном, товхимол, гарын авлага боловсруулсан	5	
3	Эмчилгээний шинэ технологи нэвтрүүлсэн	5	
4	Гадаад хэлнээс мэргэжлийн номыг орчуулж, хэвлүүлсэн	5	
5	Тасгийн эмч нарын дунд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл солилцох, шинэ мэдээлэл авах өдөр гаргасан, эмгэг судлалын хуралд оролцсон	5	
IV. Эмнэлзүйн тохиолдол, стандарт удирдамж			
1	Шинээр болон шинэчилсэн эмнэлзүйн стандарт удирдамж боловсруулж баталгаажуулсан (3-5 жил тутамд)	5	
2	Амжилттай оношилж эмчилсэн ховор тохиолдлуудыг бүртгэсэн	5	
3	Тухайн тасагт тохиолддог өвчлөлийн судалгаатай, түүнийг онолын болон шинэ мэдээллээр баяжуулсан	5	
V. Тойрон үзлэг, хяналт			
1	Эмнэлгийн дарга, сувилахуйн алба, зөвлөх эмч нарын багийн хяналт (онол, гардан үйлдэл, ур чадварын)	5	
VI. Ёс зүй			
1	Төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажилласан /тасгийн эрхлэгч болон тасаг хамт олон/	10	
2	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилласан /тасгийн эрхлэгч болон тасаг хамт олон/	10	
	Нийт	100 оноо	

Захирлын оны ... сарын өдрийн
А/З.Г. тоот тушаалын ... хавсралт

**ЭХЭМҮТ-ийн Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх албаны
дарга, тасгийн эрхлэгч нарын ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**

№	Үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо
I. Эдийн засгийн хувьд үр өгөөжтэй ажилласан байдал			
1	Зардал бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил (илүү цагийн хөлс, шинжилгээний тоо хэмжээ, эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт, ус дулаан, цахилгааны хэрэглээ г.м)	10	
2	Хариуцсан алба, тасаг нэгжийн үйл ажиллагааг зөв зохион байгуулах, тоног төхөөрөмжийн эдэлгээний хугацааг уртасгах чиглэлээр арга хэмжээ авах, эвдрэл, гэмтлийг бууруулах	10	
3	Хамт олны цаг ашиглалтыг сайжруулах (ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх)	10	
II. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил			
1	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, оролцох, хэвлэлд нийтлүүлэх	5	
III. Мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил			
1	Үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх шинэ санал санаачилга гарган нэвтрүүлэх	10	
2	Шинэ ажилтныг сургаж дадлагажуулах хөтөлбөртэй, түүнийг хэрэгжүүлсэн байх	10	
3	Алба тасаг нэгжийн хамт олны дунд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл солилцох (шинэ мэдээлэл авах өдөр гаргах)	5	
4	Мэргэжлийн ном, товхимол, гарын авлага боловсруулах, танилцуулах	5	
5	Хамт олны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөөтэй, түүнийг хэрэгжүүлсэн байх	5	
IV. Тойрон үзлэг, хяналт			
1	Хариуцсан чиглэлээр эмнэлэг, тасаг нэгжүүдээр тойрон үзлэг хяналт хийж, заавар, зөвөлгөө, танилцуулга хийх	10	
V. Ёс зүй			
1	Төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажилласан /тасгийн эрхлэгч болон тасаг хамт олон/	10	
2	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилласан /тасгийн эрхлэгч болон тасаг хамт олон/	10	
	Нийт	100 оноо	